

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь "Радио телевизийн сүлжээний газар"-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/02/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Аудитор 3.Мөнхнасан Утас: 94115644 Цахим хаяг: Munkhnasanz@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.15 № 110

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь “Радио телевизийн сүлжээний газар”-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс Говь-Алтай аймаг дахь “Радио телевизийн сүлжээний газар”-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 599 дугаар тогтоолоор 209 нэр төрлийн 2,909.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл өгсөн бөгөөд шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 606 дугаар тогтоолоор 1 ш автотээврийн хэрэгслийг нээлттэй адуудлагын

0702000253

худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн байна. Энэ тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

Тус байгууллага нь 2022 онд 1,131.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 436.4 сая төгрөгийн зардал гарган, 695.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 3.0 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1.8 сая төгрөг, бусад орлого буюу 873.6 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	/мянган. төгрөг/	
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	188,154.7	193,895.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,511,039.6	11,200,731.3
Нийт хөрөнгийн дүн	10,699,194.4	11,394,627.1
Нийт өр төлбөрийн дүн	230.0	
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,698,964.4	11,394,627.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,699,194.4	11,394,627.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	298,912.3	1,131,382.8
Үйл ажиллагааны зардлын дүн	468,759.0	436,344.6
Үйл ажиллагааны үр дүн	-169,846.7	695,038.1
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	-169,846.7	695,038.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10,868,811.0	11,394,627.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	496,787.9	496,355.3
Өмчид гарсан өөрчлөлт		
Тайлант оны үр дүн	-875,947.9	-349,699.3
Эцсийн үлдэгдэл		
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	272,130.0	255,836.6
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	276,191.0	252,839.0
Үйл ажиллагааны ЦМГ	-4,061.0	2,997.5
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-20,344.9	
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-24,405.9	2,997.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,088.6	682.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	682.7	3,680.3
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
Нийт зарлага ба цэвэр эзэллийн дүн		255,834.3
Урсгал зардал		255,834.3
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		252,834.8
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		3,680.3

Гурав. Аудитын илрүүлэлт:

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 873.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Үр дүнгийн тайланд дахин үнэлгээний Нэмэгдлийг 873.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 176.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1 заалт албан шаардлага, 1 заалт зөвлөмжийг хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

Тус газрын сэлбэг хэрэгслийн эхний үлдэгдэл 169.0 сая төгрөг, тайланд онд 17.3 сая төгрөгийн сэлбэг бэлтгэж 9.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 176.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшин ашиглаж байгаа авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох ажлыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулааг үй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Алтай аймаг дахь "Радио телевизийн сүлжээний газар"	1	873.6	-	-	1	873.6	1	873.6	-	-	-	-
Дүн	1	873.6	-	-	1	873.6	1	873.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймаг дахь "Радио телевизийн сүлжээний газар"	2	176.5	-	-	1	176.5	1	-
Дүн	2	176.5	-	-	1	176.5	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТӨҮГ	1	-	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	-	-	-	1	-	-	-